



**ЗАМ, ТЭЭВРИЙН
ЯАМ**

САЛБАРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР

**САЛБАРЫН ХЯНАЛТЫН ГАЗРЫН
2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ТАЙЛАН**

УЛААНБААТАР ХОТ
2025 он

**ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ САЛБАРЫН ХЯНАЛТЫН ГАЗРЫН
2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН**

2026.02.09

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго

Зам, тээврийн яамны Салбарын хяналтын газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”, “Үнэлгээ хийх журам”, “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2025 оны А/310 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлж дүгнэх журам”-ыг үндэслэл болгосон.

Хоёр. Танилцуулга

Зам, тээврийн яамны Салбарын хяналтын газрын 2025 оны үйл ажиллагааг Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, Сайдын тушаалын биелэлт, Төрийн нарийн бичгийн даргын тушаалын хэрэгжилт гэсэн 4 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 89.2 хувьтай байна. Хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн дүнг хүснэгт Хүснэгт №1-д харуулав.

Хүснэгт №1

№	Хяналтад байх арга хэмжээ	2025 онд төлөвлөсөн нийт арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь	Жинлэсэн хувь
1.	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	-	-	-
2.	Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	-	-	-
3.	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт	49	92.2	20
4.	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	2	75	20
5.	Сайдын тушаалын хэрэгжилт	19	91.7	10
6.	Төрийн нарийн бичгийн даргын тушаалын хэрэгжилт	60	98.3	10
7.	Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ	-	-	-

				<p>04.2.5. Агаарын хөлгийн хөөрч буух зурвас, явгалах зам, перрон, зогсоол болон бусад зам талбайн угсралт, шинэчлэлт, засварын ажлыг шалгах;</p> <p>04.2.6. Авто зам, замын байгууламжийн техник, технологийн хяналт гүйцэтгэх ажлыг шалгах;</p> <p>04.2.7. Авто зам, замын байгууламжийн ашиглалтын байдлыг шалгах;</p> <p>04.2.8. Авто замын, замын байгууламжийн барилга, засварын ажилд ашиглах материал, бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр, заводын үйл ажиллагааг шалгах;</p> <p>04.2.9. Авто замын, замын байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллагын үйл ажиллагааг шалгах;</p> <p>-Авто тээврийн чиглэлээр:</p> <p>04.1.1. Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг эрхлэх үйл ажиллагааг шалгах;</p> <p>04.1.6. Автотээврийн хэрэгслийн дугаар үйлдвэрлэх үйл ажиллагааг шалгах;</p> <p>04.1.7. Аюултай ачаа тээврийн автомашин /чиргүүл/-ыг шалгах;</p> <p>04.1.8. Ачаа тээврийн автомашин /чиргүүл/-ыг шалгах;</p> <p>04.1.9. Ачаа тээвэрлэлтийн аюулгүй байдлыг шалгах;</p> <p>04.1.10. Нийтийн тээврийн үйлчилгээний байгууллагыг шалгах;</p> <p>04.1.11. Жуулчин тээврийн үйлчилгээний автотээврийн хэрэгслийг шалгах;</p> <p>04.1.12. Суудлын автотээврийн хэрэгслийг шалгах;</p> <p>04.1.13. Таксийн үйлчилгээний автотээврийн хэрэгслийг шалгах;</p> <p>04.1.14. Хүүхэд тээвэрлэх автотээврийн хэрэгслийг шалгах;</p> <p>04.1.15. “Нийтийн тээврийн үйлчилгээний автотээврийн хэрэгслийг шалгах;</p> <p>04.1.16. Тусгай үйлчилгээний автотээврийн байгууллага, объектыг шалгах;</p> <p>04.1.17. Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох үйл ажиллагааг шалгах.</p> <p>- Усан замын тээврийн чиглэлээр:</p> <p>04.4.1. Усан замын тээврийн аюулгүй байдлыг шалгах.</p>	
2.	1.9 Агаарын тээврийн аюулгүй	I-II улирал: Агаарын тээврийн аюулгүй ажиллагааны	I-II улирал	ИНЕГ-аас 2025.03.26-ны өдрийн 01/474 тоот албан бичгээр ирүүлсэн мэдээлэл, саналыг	50

ажиллагааны одоогийн нөхцөл байдлыг судалж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулна.	одоогийн нөхцөл байдлын судалгааг хийнэ. III-IV улирал: Судалгааг үндэслэн цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулж, холбогдох газруудад хүргүүлнэ.	III-IV улирал	боловсруулж, СХГ-ын 2025.05.27-ны өдрийн 11/2451 тоот албан бичгээр ИНЕГ-т судалгаанд сүүлийн 3 жилийн иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны тайланг ирүүлэхээр хүргүүлсэн. Тус тайланг үндэслэн судалгааг нягтлан боловсруулж, дүн шинжилгээ хийж дүгнэлт, саналыг удирдлагад танилцуулсан.
---	---	---------------	---

2.2. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг дүгнэвэл:

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрээр тус газарт 2 үүрэг даалгавар өгөгдсөнөөс бүрэн хэрэгжсэн 1, хэрэгжих шатанд 1 арга хэмжээний дундаж үнэлгээ 75.0 хувь байна.

Хүснэгт №4

Нийт заалт	Үүнээс:					Хэрэгжилтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэг жээгүй	Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй	Хэрэгжих боломжгүй	
2	1	1	-	-	-	75.0

Хэрэгжих шатанд буюу 50 хувийн хэрэгжилттэй хууль тогтоомж, тогтоол шийдвэрээр өгсөн үүрэг даалгаврыг хүснэлт №5-д харуулав.

Хүснэгт №5

д/д	Заалт	Үүрэг даалгавар, биелэлт
1.	Засгийн газраас шуурхай авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2025-07-25 дугаар 2025_04	14.6.. зам, тээврийн салбарын 2025-2026 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах арга хэмжээний санал, шийдвэрийн төслийг 2025 оны 08 дугаар сарын 25-ны дотор Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх; Биелэлт: Зам, тээврийн салбарын 2025-2026 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зорилгоор Зам, тээврийн сайдын 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн “Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн томилох тухай” А/183 тоот тушаалыг Зам, тээврийн сайдаар батлуулсан. Зам, тээврийн салбарын харьяа 12 байгууллагын саналыг үндэслэн нийт 249 арга хэмжээ бүхий “Зам, тээврийн салбарын 2025-2026 оны өвөлжилтийн бэлтгэл хангах нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөө”-г 2025 оны 07 дугаар сарын 31-ний өдөр Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга баталсан. Зам, тээврийн салбарын хэмжээнд 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөөний биелэлт 68.61 хувьтай байна. Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлыг газар дээр нь шалгах ажлын хэсгийн удирдамжийг Төрийн нарийн бичгийн даргаар батлуулан шалгалтын хуваарь гарган ажиллаж байна. Салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулсан.

2.3. Сайдын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт:

Сайдын тушаалаар Салбарын хяналтын газарт өгөгдсөн 19 үүрэг даалгавраас бүрэн хэрэгжсэн 15, хэрэгжих шатанд 3, хэрэгжилт тооцох хугацаа болоогүй 1 үүрэг, даалгавар байна. Хүснэгт №6-д харуулав.

Хүснэгт №6

Нийт заалт	Үүнээс:					Хэрэгжилтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэг жээгүй	Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
19	15	3	-	1	-	91.7

Хэрэгжих шатанд буюу 50 хувийн хэрэгжилттэй 3 үүрэг даалгаврыг хүснэлт №7-д харуулав.

Хүснэгт №7

д/д	Заалт	Үүрэг даалгавар
1.		<i>2.Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01/193 дугаартай албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу Тавантолгойн нүүрс ачих ложистикийн төвийн үйл ажиллагаанд үүсээд буй нөхцөл байдлыг судалж, шийдвэрлэх тал дээр дэмжлэг үзүүлэх, зөвлөмж гаргах үүрэг бүхий ажлын хэсэг</i>
2.	<i>Ажлын хэсэг байгуулах тухай. 2025.04.07 А/92</i>	<i>3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Х.Оюунтуяа)-д, ажлын хэсгийг ажиллах нөхцөл боломжоор хангахыг ажлын хэсгийн ахлагч (М.Энхболд)-д Биелэлт: Зам, тээврийн сайдын 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн А/92 тоот тушаалын дагуу 2025 оны 04 дүгээр сарын 17-нд ЗТЯамны 301 тоот өрөөнд ажлын хэсэг анхны хурлаа хийсэн. Ажлын хэсгийн хуралд ЗТЯ, АҮЭБЯ, ЭТТ, ТТТЗ, Бодь интернэшнл ХХК -наас холбогдох албан тушаалтангууд ирж оролцсон. Ажлын хэсгийн гишүүдээс саналуудыг авч нэгтгэж байна.</i>
3.	<i>Авто зам, замын байгууламжийг хааж, түр замаар зорчуулах тухай. 2025.05.22 А/146</i>	<i>3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Авто замын бодлого зохицуулалтын газар (Ө.Баасансүрэн), Салбарын хяналтын газар (М.Энхболд)-т Биелэлт: Тушаалын хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Азийн хөгжлийн банкны зээлийн санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа L3787/3788-MON: Тогтвортой аялал жуулчлал хөгжүүлэх төсөл"-ийн хүрээнд Хөвсгөл аймгийн улсын тусгай хамгаалалттай газрын Хамгаалалтын захиргаа ба жуулчны мэдээллийн төвийн барилга угсралтын ажил болон төлбөр авах цэгийн барилга, байгууламжийн ажил гүйцэтгэхтэй холбогдуулан А1101 дугаартай улсын чанартай Мөрөн-Хатгал-Ханх чиглэлийн авто замын 92+300-92+900 хооронд хааж түр зам байгуулан ажиллаж байна. Төлбөр авах цэгийн барилга байгууламж, зам талбайн далан, суурийн ажил хийгдэж дууссан. Зам талбайн асфальтбетон хучилтын ажил дуусаагүй тул тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг түр замаар зорчуулж байна.</i>

2.4. Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт:

Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар Салбарын хяналтын газарт өгөгдсөн 60 үүрэг даалгавраас 59 үүрэг даалгавар бүрэн хэрэгжиж 1 үүрэг, даалгавар хэрэгжээгүй байна. Хүснэгт №8-д харуулав.

Хүснэгт №8

Нийт заалт	Үүнээс					Хэрэгжилтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэг жээгүй	Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
60	59	-	1	-	-	98.3

Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар өгсөн хэрэгжээгүй үүрэг даалгаврыг хүснэлт №9-д харуулав.

Хүснэгт №9

д/д	Заалт	Үүрэг даалгавар
1.	Ажлын хэсэг хэсэг тухай байгуулах тухай 2023.05.22 А/70	2.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналтын газар (Б.Бат-Өлзий), Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар (А.Мөнхбат)-т тус тус үүрэг болгосугай. Биелэлт: 2023.05.22 А/70-р тушаалаар Төмөр замын тээврийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг магадлан шалгах, санал дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдсан.

Гурав. Үнэлэлт, дүгнэлт

3.1. Төлөвлөлтийн байдал:

3.1.1. Салбарын хяналтын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин, хэрэгжүүлэх хугацааг яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан төлөвлөсөн боловч зам, тээврийн салбарын хэмжээнд төрийн хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх зүйн орчинг боловсронгуй болгох арга хэмжээний хүрээнд бусад нэгжийн оролцох үүрэг, хариуцлагыг ялгаатай тодорхойлох шаардлагатай байна. Мөн зам тээврийн салбарын байгууллагуудын төлөвлөгөөт бус хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулж, биелэлтийг авто замын салбар (2.1.4) 90-ээс доошгүй хувиар, төмөр замын салбар (2.2.2) 80-аас доошгүй хувиар, автотээврийн салбар (2.3.3) 80-аас доошгүй хувиар, усан замын тээврийн салбар (2.4.2) 80-аас доошгүй хувиар хангуулж ажиллахаар төлөвлөсөн харилцан адилгүй “зорилтот түвшин”-тэй байна.

3.2. Хэрэгжилтийн байдал:

3.2.1. Зам, тээврийн яамны Салбарын хяналтын газрын 2025 оны жилийн эцсийн үйл ажиллагааг Газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Сайдын тушаалын биелэлт, Төрийн нарийн бичгийн даргын тушаалын биелэлт гэсэн 4 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн

дүнгээр 89.2 хувиар үнэлэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.9 хувийн өсөлттэй байна.

3.2.2. Салбарын хяналтын газрын үйл ажиллагааны онцлог нь тогтмол байнгын давтагдах шинжтэй байдаг ба 2025 онд газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 47 арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажиллахаар тусгасан байна. Үүнээс гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.2 (Зам, тээврийн салбарын хяналт шалгалтад ашиглах “Хяналтын хуудас”-уудыг цаг үетэй уялдуулан шинэчлэн боловсруулж, салбарын хэмжээнд мөрдүүлнэ)-т, 1.9 (Агаарын тээврийн аюулгүй ажиллагааны одоогийн нөхцөл байдлыг судалж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулна)-т төлөвлөсөн 2 арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байсан байна.

3.2.3. Тус газраас 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан 47 арга хэмжээний хэрэгжилт 91.7 хувь байна. Үүнээс 82.6 хувь нь хүрэх түвшиндээ бүрэн хүрсэн болон хүрэх шатандаа, 17.4 хувь нь төлөвлөсөн үр дүндээ бүрэн хүрээгүй байна. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг зорилтуудын хувиар Хүснэгт №10-д харуулав.

Хүснэгт №10

Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь
Зорилт 1. Зам, тээврийн салбарын хяналтын чиглэлээр эрх зүйн орчинг боловсронгуй болгоно.	10	75
Зорилт 2. Зам, тээврийн салбарын төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх, гүйцэтгэлийн хяналт шалгалт хийнэ.	21	98
Зорилт 3. Зам, тээврийн салбарт Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж, шалган шийдвэрлэнэ.	6	93.3
Зорилт 4. Зам, тээврийн салбарт эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлнэ.	6	91.6
Зорилт 5. Зам, тээврийн салбарын бүтээн байгуулалтын төслийг байнгын ашиглалтад оруулах ажлын хэсэгт оролцох, зохион байгуулах, хяналт тавина. (Яамны төлөвлөгөө 11.2)	2	100
Зорилт 6. Төмөр зам, замын байгууламжийн барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох ажлыг зохион байгуулна.	1	100
Зорилт 7. Зам, тээврийн салбарын хяналт хэрэгжүүлэх нэгжийн улсын байцаагч нарын хүний нөөцийн судалгаа хийх, орон тоо бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, эрх олгох, сунгах, цуцлах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.	1	100

Дөрөв. Санал, зөвлөмж

4.1. Газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан ч тайлант хугацаанд “зорилтот түвшин”-д хүрээгүй арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлж ажиллах;

4.2. Зам, тээврийн сайдын 2025 оны А/310 дугаар тушаалаар баталсан журмын зургаадугаар хавсралтаар баталсан “Эрх бүхий байгууллагаас хийсэн хяналт шалгалт, аудит, хяналт-шинжилгээний хүрээнд өгсөн зөвлөмж”-ийн хэрэгжилтийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн бүрэн тайлагнаж хэвших;

4.3. Албан хаагчид байгууллагын болон нэгжийн удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь биелүүлж, улирал бүр төлөвлөгөөний хэрэгжилтийн явц,



гүйцэтгэлийн тайланг тогтоосон хугацаанд үнэн зөв тайлагнан хагас, бүтэн жилээр хийсэн ажлын нотлох баримтыг цахим хэлбэрээр ирүүлж хэвших;

4.4. Үйл ажиллагааны биелэлтийг тайлагнахдаа тухайн арга хэмжээний шалгуур үзүүлэлт, зорилтод түвшинд заасан тоо хэмжээ, чанарын үзүүлэлтийн дагуу хэрэгжилтийг тайлагнаж, ажиллахыг газрын нийт албан хаагчдад тус тус зөвлөж байна.

СХШУДАГ